

БАТЛАВ.  
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  -Б.ГАНЗОРИГ

**СУМЫН ТӨВИЙН ТӨВЛӨРСӨН ДУЛААН, ЦЭВЭР, БОХИР УСНЫ ШУГАМ  
 СҮЛЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨВ/ДОРНОГОВЬ,  
 ЭРДЭНЭ СУМ/ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР**

2019.02.18

Дугаар ЗТД-19/2018

Сайншанд

1	<b>Зураг төсөл боловсруулах үндэслэл:</b>	Аймгийн Засаг Даргын “ХОГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” үйл ажиллагааны хөтөлбөр
2	<b>Барилга байгууламжийн байршил:</b>	Дорноговь аймгийн Эрдэнэ сумын 4-р багийн нутаг дэвсгэрт
3	<b>Зориулалт, хүчин чадал</b>	Дорноговь аймгийн Эрдэнэ сумын төвийг дулаан, цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажил. Үүнд: -Дулаан механик -Дулаан хангамжийн шугам сүлжээ -Зуухны барилга -Гүний худаг -Ус түгээх байр -Усан сангийн байгууламж -Ус хангамж -Ариутгах татуурга -Гадна цахилгаан хангамж
4	<b>Үйлдвэрлэлийн технологи</b>	Техник технологийн дэвшилтэт болон байгаль, экологийн тэнцвэрийг хадгалах, хаягдалгүй технологи ашиглах
5	<b>Ажиллах горим</b>	Жилийн 4 улирлын турш ажиллах горимтой.
6	<b>Үйлдвэр аж ахуйн газар, барилга байгууламжийн бүрэлдэхүүн</b>	Сумын төвийн нэгдсэн дулаан хангамж, цэвэр, бохир усны шугам сүлжээ, эх үүсвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэхдээ холбогдох норм дүрэм, стандартыг баримтлан орчин үеийн дэвшилтэт шийдлүүдийг сонгох. Үүнд: - <b>Зуухны барилга:</b> Уг барилга нь багана суурьтай, төмөр бетон каркасан хийцтэй, цутгамал хучилттай байх бөгөөд зуухны өрөө, ажлын өрөө, ажилтны өрөө, ариун цэврийн өрөө, хувцас солих өрөөнүүдийг төлөвлөж өгөх - <b>Дулаан механик:</b> Дулааны ачаалалд тохируулан цахилгаан эрчим хүчний зарцуулалт багатай, АҮК өндөртэй, байгаль орчинд ээлтэй, хатуу түлшний тогоог суурилуулах. Зуухны дагалдах болон туслах тоноглолууд нь олон улсын стандартын шаардлагад нийцсэн байвал зохино. Зууханд усны хатуулаг бууруулах ус бэлтгэлийн тоног төхөөрөмж суурилуулах, нооц усны сав төлөвлөх - <b>Дулаан хангамж:</b> Дулаан хангамжийн шугам сүлжээг ф219х6.0 мм, ф159х4.5 мм, ф133х4.0 мм, ф133х4.0 мм, ф108х4.0 мм, ф89х3.5 мм, ф76х3.0 мм, ф57х3.0 мм, ф45х2.5 мм, ф38х2.5 мм-ийн голчтой ГОСТ10704-91 маркийн ган хоолойгоор угсрахаар төлөвлөж өгнө. Дулаан сувагт цэвэр усны шугамыг хамтад нь явахаар төлөвлөх - <b>Гүний худаг:</b> Гүний худгийн барилга нь 1 давхар, төмөр бетон цутгамал шугаман суурьтай, цутгамал төмөр бетон хучилттай, даацны

		<p>тоосгон ханатай байхаар төлөвлөх</p> <p><b>-Ус түгээх байр:</b> Ус түгээх байрны 2 ш барилга нь цутгамал хучилттай, даацын тоосгон ханатай, 1 давхар барилга байхаар төлөвлөх. Ус түгээх байр нь 24 цагийн турш тасралтгүй ажиллах, автомат тоног төхөөрөмж бүхий ухаалаг байхаар төлөвлөх</p> <p><b>-Усан сангийн байгууламж:</b> Усан сангийн байгууламжийг техникийн нөхцөлд заасан ачаалалд тохируулан сонгох бөгөөд хана, суурь, хучилт нь цутгамал төмөр бетон хийцтэй, өгөх, түгээх, халилтын ба юүлэх хоолойтой, агааржуулалт ба дохиоллын камерууд, засвар үйлчилгээний болон гэрлийн нээхийгээр тоноглогдсон байхаар төлөвлөх</p> <p><b>-Усан хангамж:</b> Сумын төвийн ус хангамжийг шинээр төлөвлөгдөх гүний худгаас усан сангийн байгууламжаар дамжуулан хэрэглэгчдэд түгээхээр тооцох. Усан сангийн түвшнийг гүний худгийн насос, уурын зууханд байрлах хэрэгцээний усны даралт өргөх насосны ажиллагаатай уялдуулан төлөвлөх. Цэвэр усны шугамыг ISO4427-2007 SDR 11 маркийн хуванцар хоолойгоор угсрахаар төлөвлөх</p> <p><b>-Ариутгах татуурга:</b> Гадна бохир усыг өөрийн ургалаар нэгтгэн ф100 мм, ф150 мм, ф150 мм, ф200 мм-ийн голчтой хуванцар хоолойгоор угсрахаар төлөвлөсөн бөгөөд цэвэрлэх байгууламжаар дамжуулахаар төлөвлөх. Бохир усыг Q=100 м<sup>3</sup>/хон хүчин чадалтай, энгийн биологийн цэвэрлэх технологитой, септик танктай байхаар төлөвлөх</p> <p><b>-Гадна цахилгаан хангамж:</b> Цахилгаан хангамж- олгогдсон техникийн нөхцлийн дагуу төвийн эрчим хүчний шугамд холбогдоно.</p>
7	Барилгын үндсэн бүтээц, материал	<p><u>Гадна дулаан:</u> Ган хоолой</p> <p><u>Гадна усан хангамж:</u> -MNS ISO 4427-2007 стандартын шаардлага хангасан SDR11 маркийн хуванцар хоолой</p> <p>-ГОСТ3262-75 маркын цайрдаан хоолой</p> <p><u>Гадна ариутгах татуурга:</u> Хуванцар хоолой</p> <p><u>Уурын зуух, Усан сан, Ус түгээх байр, Цэвэрлэх байгууламжийн барилга:</u></p> <p><u>Суурь:</u> Цутгамал төмөр бетон баганан болон цутгамал хавтан суурьтай</p> <p><u>Даацын бүтээц:</u> Даацын тоосгон хана болон бүрэн цутгамал ханатай.</p> <p><u>Гадна хана:</u> Тоосгон ханатай.</p> <p><u>Дотор хана:</u> Тоосго, шил, бусад</p> <p><u>Хучилт:</u> Цутгамал болон угсармал төмөр бетон</p> <p><u>Дээвэр:</u> Хавтгай дээвэртэй</p> <p><u>Цонх:</u> Хуванцар рамтай /вакуум/ шилэн цонх</p> <p><u>Хаалга:</u> Шил, төмөр, модон хаалга</p>
8	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	Цахилгаан хангамж- олгогдсон техникийн нөхцлийн дагуу төвийн эрчим хүчний шугамд холбогдоно.
9	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай зам тээвэр	Шаардлагагүй.
10	Зураг төслийн иж бүрдэл	<p><u>Ажлын зургийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нүүр хуудас /батлагдсан байх/</li> <li>- ЕТ - Ерөнхий төлөвлөгөө, өндөржилт /автозам/</li> <li>- ГДГ - Гадна дулаан</li> <li>- УХАТ – Ус хангамж, ариутгах татуурга</li> </ul>

		<p><u>Уурын зуух, Усан сан, Ус түгээх байр, Цэвэрлэх байгууламжийн барилга:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- БА-Барилга архитектур</li> <li>- ББ-Барилгын бүтээц</li> <li>- ХАС-Халаалт, агаар сэлгэлт</li> <li>- ЦБУ-Цэвэр, бохир ус</li> <li>- ХТ-Хүчит төхөөрөмж</li> <li>- ДГ-Дотор гэрэлтүүлэг</li> <li>- Төсөвт өртгийн тооцоо</li> </ul>
11	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
12	Зураг төслийн байгууллага	Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ын Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ЗТ-3.2, ЗТ-3.6, ЗТ-3.5, ЗТ-3.4 тусгай зөвшөөрөл эрх бүхий компани оролцох боломжтой.
13	Хөрөнгө оруулагч, захиалагч байгууллага:	Дорноговь аймгийн ЗДТГазар
14	Онцгой нөхцөл:	<ul style="list-style-type: none"> <li>- Газар хөдлөлийн 6 балл.</li> <li>- Зураг төсөл боловсруулах явцад захиалагчийн зүгээс нэмэлт өөрчлөлтийг харилцан тохиролцсоны үндсэн дээр оруулж болно.</li> <li>- Эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал багатайгаар төлөвлөх</li> </ul>
15	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Галын ангиллын категор-2</li> <li>- Гал тэсвэржилтийн зэрэг-2</li> </ul>
16	Байгаль орчин үнэлгээ	-
17	Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ	-

ГХБХБГ-ЫН ДАРГА



/Ц ОЮУНСАЙХАН/

ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА /Ц БАЯРМАА/